



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2022/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитор:

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.25 № 16/46

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АШУУИС-ИЙН ДОРНОГОВЬ  
АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ  
УХААНЫ СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ М.ОТГОНЧИМЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

|                                                |                                                   | /сая төгрөгөөр/       |                       |
|------------------------------------------------|---------------------------------------------------|-----------------------|-----------------------|
|                                                | Үзүүлэлт                                          | 2020.12.31            | 2021.12.31            |
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                       |                       |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | <u>2,541.3</u>        | <u>2,861.7</u>        |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | <u>3,037.6</u>        | <u>3,131.3</u>        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b><u>5,578.8</u></b> | <b><u>5,993.0</u></b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | <u>164.0</u>          | <u>24.6</u>           |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | <u>5,414.8</u>        | <u>5,968.4</u>        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b><u>5,578.8</u></b> | <b><u>5,993.0</u></b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                       |                       |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,720.4               | 1,893.4               |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,244.6               | 1,339.8               |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b><u>475.8</u></b>   | <b><u>553.6</u></b>   |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        |                       |                       |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b><u>475.8</u></b>   | <b><u>553.6</u></b>   |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                       |                       |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 5,873.6               | 5,414.8               |
|                                                | Тайлант оны үр дүн                                |                       | 553.6                 |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>5,873.6</b>        | <b>5,968.4</b>        |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                       |                       |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | <u>1,190.5</u>        | <u>1,298.3</u>        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | <u>1,126.0</u>        | <u>1,309.5</u>        |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b><u>64.6</u></b>    | <b><u>(11.2)</u></b>  |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b><u>(7.5)</u></b>   | <b><u>(108.5)</u></b> |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 |                       |                       |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>57.1</b>           | <b>(119.7)</b>        |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 965.3                 | 1,022.4               |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,022.4               | 902.6                 |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                       |                       |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          |                       | <b>1,328.0</b>        |
|                                                | Урсгал зардал                                     |                       | 1,219.5               |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                       | 108.5                 |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             |                       | <b>1,296.4</b>        |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           |                       | 364.6                 |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             |                       | 931.8                 |

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

АШУҮИС-н Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль нь диплом, бакалаврын боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг байна.

Алсын хараа: Олон улсын стандартад нийцсэн орон нутаг дахь манлайлагч их сургууль байх.

Эрхэм зорилго: Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдлийн хангасан орон нутаг дахь тэргүүлэх их сургууль болох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

### **Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа оруулсан, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийт орлого зарлага болон тушаал шийдвэртэй холбоотой байршуулбал зохих бүх мэдээллийг бүрэн байршуулсан байна.

### **Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### **Тав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 0.8 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.0 сая төгрөгийн 1 зөвлөмж, 0.6 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

### **Залруулсан алдаа:**

*1. БҮТЭЗ-ийн материалын 0.8 сая төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардалд бүртгээснийг залруулав.*

### **Албан шаардлага:**

Тайлант хугацаанд 0.6 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зааврын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

**Зөвлөмж:**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал****1.1. Илрүүлэлт:**

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 280.5 сая төгрөгийн 125 нэр төрлийн хөрөнгө байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, эсхүл дахин шинээр үнэлгээ тогтоон цаашид ашиглах асуудлыг шийдвэрлэх.

**7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

| №    | Төсвийн захирагчийн ангилал                                    | Байгууллага, нэгжийн тоо |                             |   |   | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|------|----------------------------------------------------------------|--------------------------|-----------------------------|---|---|-------------------------|----------------|-------|----------------------------|
|      |                                                                | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |   |   | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A    | 1                                                              | 2                        | 3                           | 4 | 5 | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1    | АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар анагаах ухааны сургууль | 1                        | 1                           | - | - | 1                       | -              | -     | -                          |
| НИЙТ |                                                                |                          |                             |   |   |                         |                |       |                            |

**7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/сая төгрөгөөр/

| №    | Аудитад хамрагдсан байгууллагын нэр                            | Нийт алдаа, зөрчлийн |     | Үүнээс    |     |               |     |                 |     |         |     |
|------|----------------------------------------------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|      |                                                                |                      |     | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|      |                                                                | Тоо                  | Дүн | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| A    | 1                                                              | 2                    | 3   | 4         | 5   | 6             | 7   | 8               | 9   | 10      | 11  |
| 1    | АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар анагаах ухааны сургууль | 3                    | 1.4 | 1         | 0.8 | -             | -   | 1               | 0.6 | 1       | -   |
| НИЙТ |                                                                | 3                    | 1.4 | 1         | 0.8 | -             | -   | 1               | 0.6 | 1       | -   |